

## ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00000915

Огноо:	2022-03-22	Дансны дугаар	Дүн /тоогоор/
Төлөгч:	Диспетчерийн үндэсний төв ХХК	Дебит	7,200,000.00
Төлөгчийн:	Худалдаа Хөгжлийн Банк	406002860	
Хүлээн авагч:	Эфэсконстракшн ХХК	Кредит	
Хүлээн авагчийн:	Худалдаа Хөгжлийн Банк	416008998	
Мөнгөний дүн тоогоор (үсгээр)	7,200,000.00	.... хоногийн ... хувийн торгууль ...	
( Долоон сая хоёр зуун мянган төгрөг 00 мөнгө )		.... төгрөг .... мөнгө	
Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн:	Дагалдах баримтын №		Дүн (торгуулийн хамт)
	Огноо: 2022-03-22	****	
Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр)	морьтон цогцолборын цэвэрлэгээний төлбөр 2022.02.11-11.10 рд:2699877		Гүйлгээний утга (Төлбөрийн зориулалт)
Гүйцэтгэх захирал: <i>Т. Дамсжав</i>	Банкинд гүйлгээ хийсэн		Төлөх хугацаа
Тамга	2022-03-22 ... оны ... сарын ...		Төлбөрийн ээлж
Ерөнхий нягтлан бодогч: <i>Т. Дамсжав</i>	(тэмдэг, гарын үсэг)		



БАТЛАВ: "ЭФЭСКОНСТРАКШН" ХХК  
ЗАХИРАЛ М.ЛХАГВАСҮРЭН



БАТЛАВ: "ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВ" ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Г.БАЛЖИННЯМ



### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Нэг талаас "ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК /РД: 5557429/ /цаашид "Захиалагч" гэх/ түүнийг төлөөлж Захиргаа удирдлагын албаны дарга албан тушаалтай Б.Биндэръяа, нөгөө талаас "ЭФЭСКОНСТРАКШН" ХХК /РД: 5557429//цаашид "Гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлж Ерөнхий Менежер албан тушаалтай Сугирдож овогтой Долгормаа нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон, харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ЗААЛТ

- 1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн хүсэлтийн дагуу, түүний материалаар, түүний түрээсээр эзэмшиж буй Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Морьтон цогцолбор 3 дугаар давхар 303 тоот хаягт байх оффисын зориулалттай 176.06 мкв объектыг /цаашид оффис гэх/ цэвэрлэх үйлчилгээ үзүүлнэ.
- 1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, ажлын хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр хугацаанд төлнө.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд ажлын өдрийн тооллогыг удирдлага болгоно.
- 2.2 Ажил гүйцэтгэх хугацаа: 2022 оны 02 -р сарын 11 өдөр – 2022 оны 12 -р сарын 31 өдөр
- 2.3 Ажил гүйцэтгэх давтамж: Өдөр бүр 1-2 удаа

### ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

- 3.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс сарын 800,000 /Найман зуун мянга/ төгрөг байна.
- 3.2 Ажлын үр дүнг сар бүрийн эцэст цэвэрлэсэн тоо хэмжээнд суурилж төлнө.

### ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Ажил гүйцэтгэхэд шаардагдах цэвэрлэгээний материал болон орчныг ажил гүйцэтгэгчид бэлтгэж өгнө.
- 4.2 Ажил гүйцэтгэгчид үүргээ биелүүлэхэд шаардагдах зайлшгүй мэдээллийг өгнө.
- 4.3 Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авах үед ажил гүйцэтгэж буй ажилтанд хэлж засварлуулах үүрэгтэй. Хэрэв ажил гүйцэтгэл дутуу гэж үзвэл гүйцэтгэгч компанийн удирдлагад шаардлага гаргах эрхтэй
- 4.4 Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй
- 4.5 Захиалагч долоо хоног бүр гүйцэтгэгчийн ажилд үнэлгээ өгнө.

### ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.2 Ажлыг тодорхой нэг ажилтан томилон биечлэн гүйцэтгэнэ.
- 5.3 Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалын зарцуулалтын талаар захиалагчид тайлагнаж үлдэгдэл материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.
- 5.4 Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.

### ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсвэл захиалагч нэхэмжлэхийн дагуу төлбөрөө 3 хоногийн дотор төлөөгүй бол хугацааг хэтрүүлсэн хоног тутам 0,1 хувийн алданги төлнө.
- 6.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй
- 6.3 Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

### ДОЛОО. БУСАД ЗААЛТ

- 7.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо г.м/ -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 7.2 Гэрээний хугацаа нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.3 Талууд 2 тал ямар нэг санал гаргаагүй тохиолдолд гэрээг үргэлжлэн сунгагдсанд тооцно.
- 7.4 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.5 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 7.6 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 7.7 Уг гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд хувиуд адил хүчин төгөлдөр байна.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ТҮРЭЭСЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ДИСПЕТЧЕР

Б.Баатар /Б.БААТАР/  
ЗАХ ЗЭЭЛ САНХҮҮ ХАРИУЦСАН ДЭД  
ЗАХИРАЛ

Ц.Өнөрmaa /Ц.ӨНӨРМАА/

ТЕХНИК ХЯНАЛТ СУДАЛГАА ХӨГЖИЛ  
ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ

Б.Эрхэмзаяа /Б.ЭРХЭМЗАЯА/  
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЛБАНЫ ДАРГА  
Б.Биндэръяа /Б.БИНДЭРЪЯА/

ЭДИЙН ЗАСАГ САНХҮҮГИЙН АЛБАНЫ  
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ

Т.Бямбажав /Т.БЯМБАЖАВ/  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
С.Намчиндорж /С.НАМЧИНДОРЖ/

#### ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот 17060  
Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн  
Өргөн чөлөө Засгийн газрын XIV байр  
4,5 давхар  
Утас: 7004 1371  
Факс: 7004 3467

#### ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

С.Долгормаа /С.ДОЛГОРМАА/

МЕНЕЖЕР

Э.Баяржаргал /Э.БАЯРЖАРГАЛ/



#### ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
20-р хороо, Морьтон цогцолбор, 12-р  
давхар  
Утас: 77190099, 99070600, 91960999  
Банк: Худалдаа Хөгжлийн Банк  
Дансны дугаар: 416008998  
Э.шуудан: [moriton@efesconstruction.mn](mailto:moriton@efesconstruction.mn)